

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/14/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан  
Утас: 99008827

Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хэнтий аймгийн Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ .....	3
2.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	4
2.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	4
2.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	5
2.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
3.	Аудитын тайлан .....	10
3.1.	Оршил .....	10
3.2	БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ .....	10
3.3	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4	Материаллаг байдал .....	11
3.5	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	11
3.5.1	Мөнгөн хөрөнгө .....	11
3.5.2	Авлага .....	12
3.5.3	Урьдчилгаа .....	13
3.5.4	Бараа материал .....	13
3.5.4	Үндсэн хөрөнгө .....	13
3.5.5	Өр төлбөр .....	14
3.5.6	Засгийн газрын хувь оролцоо .....	14
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	15
3.7	Шилэн дансны мэдээлэл .....	17
3.9	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	18
3.10.	ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ .....	19
4.	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ .....	19
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖДБДС	Жижиг дунд бизнесийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.04.22 № 415  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАН-ЭРДЭНЭ ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хэнтий аймгийн Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

023030007

**2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		1,023,639.30	1,176,554.80
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	339,137.60	434,580.20
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	284,399.00	287,438.40
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	400,102.70	454,536.20
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		4,368,202.90	5,058,817.20
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	4,368,202.90	5,058,817.20
39200	Биет хөрөнгө		4,193,492.70	4,884,350.70
39300	Биет бус хөрөнгө	13	174,710.20	174,466.50
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		5,391,842.20	6,235,372.00
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		96,314.50	9,250.80
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	96,314.50	9,250.80
41300	Өглөг	17а, 17б	96,314.50	9,250.80
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		5,295,527.70	6,226,121.20
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		5,295,527.70	6,226,121.20
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,375,208.40	1,370,419.90
51200	Хуримтлагдсан үр дүн		2,043,750.10	2,979,132.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,876,569.20	1,876,569.20
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		5,391,842.20	6,235,372.00

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,524,392.40	4,580,578.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО		129,054.30	275,714.90
110	Орлогын албан татвар		104,552.20	69,807.70
1100	Хувь хүний орлогын албан татвар		104,552.20	69,807.70
113	Хөрөнгийн албан татвар		5,550.00	122,826.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж		18,952.10	83,081.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	668,034.40	961,788.10
120	Нийтлэг татварын бус орлого		668,034.40	961,788.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,727,303.70	3,343,075.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,997,412.50	3,346,281.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,997,412.50	3,346,281.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,890,008.50	3,210,864.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,681,856.80	1,792,289.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		212,454.20	237,198.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		433,264.70	389,281.90
2104	Хангамж, бараа материалын зардал		73,050.90	71,459.40
2105	Нормативт зардал		113,255.10	214,053.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		10,540.60	21,088.90
2107	Томилолт, зочны зардал		9,697.50	10,609.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		60,873.40	81,862.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		295,015.10	393,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		107,404.00	135,417.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		526,979.90	1,234,297.50
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-	4,788.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		85,592.50	303,704.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		441,387.40	935,382.00

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		3,070,909.20	3,686,282.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО		129,054.30	275,714.90
110	Орлогын албан татвар		104,552.20	69,807.70
1100	Хувь хүний орлогын албан татвар		104,552.20	69,807.70
113	Хөрөнгийн албан татвар		5,550.00	122,826.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж		18,952.10	83,081.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		14,796.80	9,538.90
1181	Газрын төлбөр		4,155.20	7,455.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		-	66,087.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		214,551.30	149,134.10
120	Нийтлэг татварын бус орлого		214,551.30	149,134.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,727,303.70	3,261,433.70
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,781,141.80	3,180,337.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,781,141.80	3,180,337.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,673,878.90	3,044,679.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,693,323.10	1,792,289.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		214,159.20	237,198.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		340,650.20	481,896.40
2104	Хангамж, бараа материалын зардал		150,754.40	75,919.60
2105	Нормативт зардал		114,990.10	225,831.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		24,682.50	38,048.20
2107	Томилолт, зочны зардал		9,697.50	10,609.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		46,233.20	83,521.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		79,388.70	99,364.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		107,262.90	135,658.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		289,767.50	505,944.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		108,478.40	375,002.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		108,478.40	375,002.10
2200	Дотоод эх үүсвэрээр		108,478.40	375,002.10
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(108,478.40)	(375,002.10)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		(62,000.00)	(35,500.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		62,000.00	35,500.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		119,289.00	95,442.60
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		219,848.60	339,137.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		339,137.60	434,580.20

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,854,140.30	-	4,854,140.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,854,140.30	-	4,854,140.30
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	441,387.40	-	441,387.40
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,295,527.70	-	5,295,527.70
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,295,527.70	-	5,295,527.70
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,295,527.70	-	5,295,527.70
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	(4,788.50)	-	(4,788.50)
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	935,382.00	-	935,382.00
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,226,121.20	-	6,226,121.20


## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,484,911.70	3,214,115.95	270,795.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,084,021.00	2,897,916.24	186,104.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,025,955.60	2,853,097.59	172,858.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,787,291.00	1,744,018.90	43,272.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	239,367.00	232,382.29	6,984.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	512,301.00	480,786.38	31,514.63
2104	Хангамж, бараа материалын зардал	59,618.60	58,281.86	1,336.74
2105	Нормативт зардал	141,314.90	121,155.63	20,159.27
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,239.10	67,371.31	2,867.79
2107	Томилолт, зочны зардал	11,955.20	10,359.00	1,596.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	132,345.70	69,012.68	63,333.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,523.10	69,729.53	1,793.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,065.40	44,818.65	13,246.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,065.40	44,818.65	13,246.75
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	281,630.90	280,699.71	931.19
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	119,259.80	35,500.00	83,759.80
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,484,911.70	3,315,130.90	169,780.80
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,796,121.50	1,739,531.49	56,590.01
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,366,885.60	1,432,118.65	(65,233.05)
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,233.80	18,881.09	13,352.71
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	289,670.80	124,599.67	165,071.13
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	185,570.84	(185,570.84)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	286,585.79	(286,585.79)
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1.14	1.17	(0.03)
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.01	0.01	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.15	0.15	(0.00)
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	0.83	0.86	(0.03)
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	0.65	0.68	(0.03)
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	0.18	0.18	0.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.15	0.15	(0.00)



**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Тайлант хугацаа: 2021.12.31

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Дүн 2021.12.31 СНУА0046 9074082
А	1
<b>II НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>319,727.31</b>
<b>21 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>259,727.31</b>
<b>210 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>225,477.31</b>
2101 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,270.97
2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,816.28
2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,110.00
2104 Хангамж, бараа материалын зардал	17,637.74
2105 Нормативт зардал	104,676.07
2106 Эд хогшил, урсгал засварын зардал	3,019.37
2107 Томилолт, зочны зардал	249.99
2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,477.40
2109 Бараа үйлчилгээний бусад зардал	31,219.50
<b>213 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,250.00</b>
2132 Бусад урсгал шилжүүлэг	34,250.00
<b>22 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>60,000.00</b>
2200 Дотоод эх үүсвэрээр	60,000.00
<b>I ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>319,727.31</b>
1311 Нэмэлт санхүүжилтийн орлого	319,727.31

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Оршил**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналыг боловсронгуй болгох, авлагыг барагдуулах зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Хуланхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ**

Төсвийн тухай хуульд “төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 5.4.-д Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байна. Үүнд:

15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

15.4.2.энэ хуулийн 14.2.8-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

Батноров сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,972.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 39.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 29.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 629.6 сая төгрөгөөр өмнөх оноос буурсан тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг 25.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### **3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**

#### **3.5.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 339.1 сая, эцсийн үлдэгдэл 434.5 сая төгрөг болж, 95.4 сая төгрөгөөр өссөн байна.

**Хэнтий аймгийн Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл**

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	339.04	429.40	90.37	94.68
Замд яваа мөнгөн хөрөнгө	0.10	5.18	5.07	5.32
<b>Дүн</b>	<b>339.14</b>	<b>434.58</b>	<b>95.44</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын 145.9 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн 117.7 сая, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн 55.5 сая, Сум хөгжүүлэх сангийн 48.3 сая, Байгаль хамгаалах сангийн 64.7 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн 0.4 сая, Ахмадын сангийн 2.0 сая, нийт 434.5 сая төгрөг төрийн сангийн харилцахад, Эмийн эргэлтийн сангийн 0.05 сая төгрөг арилжааны банкны харилцах дансанд байршиж байна.

Зам яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд үйл ажиллагааны орлогын 0.5 сая, хөрөнгийн орлогын 1.1 сая, газрын төлбөрийн 0.4 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.2 сая, малын тоо толгойн албан татварын 2.0 сая, нийт 5.2 сая төгрөг байна.

Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 51.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 56.6 сая төгрөгийг улсын төсөвт, нийт 108.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Байгууллагаар нь хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт №2. Төвлөрүүлсэн үлдэгдэл**

/сая төгрөг/

Байгууллага	Төвлөрүүлсэн үлдэгдэл						Нийт
	Улсын төсөвт			Орон нутгийн төсөвт			
	Үндсэн данс	Нэмэлт данс	Нийт	Үндсэн данс	Нэмэлт данс	Нийт	
ИТХ			-	3.0		3.0	3.0
ЭДТГ			-	29.1		29.1	29.1
ЕБС	34.9		34.9	1.5		1.5	36.4
ЭМТ			-	1.6		1.6	1.6
Цэцэрлэг	21.7		21.7	1.0		1.0	22.7
Соёлын төв			-	15.3		15.3	15.3
<b>Дүн</b>	<b>56.6</b>	<b>-</b>	<b>56.6</b>	<b>51.5</b>	<b>-</b>	<b>51.5</b>	<b>108.1</b>

**3.5.2 Авлага**

Авлага дансны эхний үлдэгдэл 284.4 сая, эцсийн үлдэгдэл 287.4 сая болж 3.0 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл**

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага			-
Төлбөртэй үйлчилгээний авлага			81.6
Татаас, санхүүжилтийн авлага			-
Зээлийн хүүгийн авлага			-
Дансны авлага /ТӨҮГ/			-
Бусад авлага			-
Зээлийн авлага		284.4	205.8
<b>Дүн</b>		<b>284.4</b>	<b>287.4</b>
			<b>3.0</b>

Эх сурвалж: Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Хэнтий аймгийн Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Төлбөртэй үйлчилгээний авлага нь Эрүүл мэндийн төвд ЭМДС-аас олгох Ковид-19 цар тахлын санхүүжилт орж ирээгүйтэй холбоотой, Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагын үлдэгдэл 117.9 сая, Жижиг дунд бизнесийг дэмжих сангийн үлдэгдэл 87.9 сая төгрөг байна. Нийт авлагын 71.6 хувийг зээлийн авлага эзэлж байна.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 400.1 сая, эцсийн үлдэгдэл 454.5 сая төгрөг болж, 54.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>15.6</b>	<b>24.2</b>	<b>8.6</b>
Тусгай зориулалттай материал			-
Эм боох материал	15.6	24.2	8.6
Дуусаагүй үйлдвэрлэл			-
<b>Хангамжийн материал</b>	<b>331.2</b>	<b>375.8</b>	<b>44.6</b>
Бичиг хэргийн материал	3.7	3.7	-
Аж ахуйн материал	295.9	332.8	36.9
Сэлбэг хэрэгсэл			-
Түлш, шатах тослох материал			-
Барилгын засварын материал			-
Хүнсний материал	0.1	4.3	4.2
Бусад хангамжийн материал	31.5	35.0	3.5
<b>Мал амьтад</b>	<b>53.3</b>	<b>54.5</b>	<b>1.2</b>
<b>Дүн</b>	<b>400.1</b>	<b>454.5</b>	<b>54.4</b>

*Эх сурвалж: Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд 485.5 сая төгрөгийн бараа материалыг орлого авснаас 442.3 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 43.2 сая төгрөгийн бараа материалыг хандив болон үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна. Нийт 431.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,405.1 сая, эцсийн үлдэгдэл 6,271.2 сая төгрөг болж, 866.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>5,229.0</b>	<b>6,095.1</b>	<b>866.1</b>
Барилга, байгууламж, орон сууц	3,766.5	4,571.2	804.7
Авто-тээврийн хэрэгсэл	228.7	178.2	(50.5)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	869.3	956.4	87.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	206.5	232.5	26.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	55.2	55.2	-
Бусад үндсэн хөрөнгө	81.9	80.7	(1.2)
Дуусаагүй барилга, байгууламж			-
Ном	20.9	20.9	-
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>176.1</b>	<b>176.1</b>	<b>-</b>
Программ хангамж	2.1	2.1	-
Бусад биет бус хөрөнгө	174.0	174.0	-
<b>Дүн</b>	<b>5,405.1</b>	<b>6,271.2</b>	<b>866.1</b>

*Эх сурвалж: Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

**Хэнтий аймгийн Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Үндсэн хөрөнгө данс худалдаж авсан 84.3 сая, хандиваар 5.0 сая, үнэ төлбөргүйгээр хүлээн авсан 878.5 сая, нийт 967.8 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж дуудлага худалдаагаар худалдсан тээврийн хэрэгслийн 100.5 сая, шилжүүлсэн 1.2 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 96.3 сая, эцсийн үлдэгдэл 9.2 сая төгрөг болж, 87.1 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
<b>Өглөг</b>	<b>92.6</b>	<b>9.2</b>	<b>(83.4)</b>	
Ажиллагсадтай холбогдсон өглөг				-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	92.6	9.2	(83.4)	
<b>Бусад өглөг</b>	<b>3.7</b>	<b>-</b>	<b>(3.7)</b>	
Дансны өглөг /ТӨҮГ/	3.7		(3.7)	
<b>Нийт дүн</b>	<b>96.3</b>	<b>9.2</b>	<b>(87.1)</b>	

*Эх сурвалж: Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд байгаа 9.2 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн бараа үйлчилгээний зардлын өглөг байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,295.6 сая, эцсийн үлдэгдэл 6,226.2 сая болж, 930.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 7. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО*

/САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>Засгийн газрын оруулсан капитал</b> /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	<b>1,375.2</b>	<b>1,370.4</b>	<b>(4.8)</b>	<b>22.1</b>
<b>Хуримтлагдсан үр дүн:</b>	<b>2,043.8</b>	<b>2,979.2</b>	<b>935.4</b>	<b>47.8</b>
Өмнөх үеийн үр дүн	1,602.4	2,043.8	441.4	
Тайлант үеийн үр дүн	441.4	935.4	494.0	
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>1,876.6</b>	<b>1,876.6</b>	<b>-</b>	<b>30.1</b>
<b>Дүн</b>	<b>5,295.6</b>	<b>6,226.2</b>	<b>930.6</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: : Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын сан дансны үлдэгдэл 1,370.4 сая болж 4.8 сая төгрөгөөр буурсан Эмийн эргэлтийн сан татан буугдсанаас шалтгаалсан байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 2,979.2 сая төгрөг болж тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

### 3.5.7 Орлогын данс

Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь татварын орлого 275.7 сая, татварын бус орлого 961.8 сая, тусламж санхүүжилтийн орлого 4,718.9 сая, нийт 5,956.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

### 3.5.8 Зардлын данс

Үйл ажиллагааны нийт зардал 4,722.1 сая, үйл ажиллагааны бус зардал 303.7 сая төгрөг байна. Үйл ажиллагааны бус зардал нь хөрөнгийг данснаас хассантай холбоотой бөгөөд ОНХС-ийн 230.7 сая төгрөгийн хөрөнгийн зардлыг үнэ төлбөргүй гарсан зардал дансанд бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Батноров сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 08 дугаар сарын 27-ны 03 дугаар тогтоолд зааснаар төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 86.7 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 297.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 211.2 сая төгрөгөөр буюу 343.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

№	Орлогын нэр төрөл	2021 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	23.0	23.8	0.8	103.5
2	Хөрөнгө борлуулсны орлого	-	5.3	5.3	
3	Хөрөнгийн орлого	29.0	40.7	11.7	140.3
4	Бууны албан татвар	5.4	4.1	(1.3)	75.9
5	Улсын тэмдэгтийн хураамж	2.0	1.5	(0.5)	75.0
6	Түгээмэл тархацтай АМНАТ	3.5	1.4	(2.1)	40.0
7	Хог хаягдлын хураамж	6.0	6.7	0.7	111.7
8	Агнуурын нөөц ашигласны төлбөр	1.1	66.1	65.0	6,009.1
9	Газрын төлбөр	2.4	7.5	5.1	312.5
10	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	0.3	-	(0.3)	-
11	Торгуулийн орлого	6.0	8.8	2.8	146.7
12	Бусад орлого	8.0	13.3	5.3	166.3
13	Малын тоо толгойн албан татвар		118.7	118.7	
<b>Нийт дүн</b>		<b>86.7</b>	<b>297.9</b>	<b>211.2</b>	<b>343.6</b>

Орлогын төлөвлөгөө давж биелсэн нь төлөвлөгдөөгүй шонхор шувуу тусгай зөвшөөрлөөр бариулсны төлбөрийн орлого орсон, малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байна. Кодив -19 цар тахалтай холбоотой барилгын компаниуд үйл ажиллагаа явуулаагүйгээс түгээмэл тархацтай АМНАТ -ын орлого тасарсан байна.

**Аудитын илрүүлэлт:** Татварын орлогын гүйцэтгэлтэй холбоотой 4.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

**ТТЗ:** Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал 0.3 сая, бууны албан татвар 1.3 сая, улсын тэмдэгтийн хураамж 0.5 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 2.1 сая, нийт 4.2 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлэх талаар зөвлөмж хүргүүлнэ.

## Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн татварын орлогыг 68.7 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 18.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 86.7 сая төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-аас нийт зардал, эх үүсвэрийг 3,484.9 сая төгрөгөөр баталсан байна.

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 3,484.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3,084.0 сая төгрөгийг урсгал зардалд, 281.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлд 119.2 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 967.4 сая төгрөгөөр батлагдсаныг бүрэн олгосон байна.

Нийт зардлыг тусгай зориулалтын шилжүүлгээс 1,796.1 сая, орон нутгийн төсвөөс, 1,207.6 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 159.3 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 32.2 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 104.1 сая, урьд оны үлдэгдлээс 185.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

- Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс, орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт, Орон нутгийн хөгжлийн сангаас олгох санхүүжилтийг бүрэн олгосон байна.
- Орон нутгийн хөгжлийн санд малын тоо толгойн албан татварын 116.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.
- ЭМТ-д ЭМДС-аас 32.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 17.9 сая төгрөг олгож, 14.3 сая төгрөгийг дутуу олгосон байна.
- Үндсэн үйл ажиллагааны орлогод 116.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогод 8.6 сая, нийт 124.6 сая төгрөг бүрдүүлж батлагдсан төлөвлөгөөг 20.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,214.1 сая төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардал 172.9 сая төгрөг, хөрөнгийн зардал 1.0 сая төгрөг, эргэж төлөгдөх зээл 83.7 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардал 13.2 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна. Үүнд:

Урсгал зардлын гүйцэтгэлийг авч үзвэл цалин хөлс болон нэмэгдэл урамшил 43.3 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 7.0 сая, байр ашиглалтын тогтмол зардал 31.5 сая, хангамжийн бараа материалын зардал 1.3 сая, нормативт зардал 121.1 сая, эд хогшил худалдан авах зардал 2.9 сая, албан томилолтын зардал 1.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 63.3 сая, бараа үйлчилгээний бусад зардал 1.8 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Төсвөөс зарцуулаагүй үлдэгдлээс 51.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 56.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 231.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ажил хийгдэхээр төлөвлөснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Эргэж төлөгдөх зээл 83.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Жижиг дунд бизнесийг дэмжих сангаас олгох 47.6 сая, Сум хөгжүүлэх сангаас олгох 36.1 сая төгрөгийн зээлийг олгоогүйтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:** Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад төсвийг хэмнэлтгүй, үрэлгэн, зориулалт бус зарцуулсан зэрэг нийт 83.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

1. Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас **ЗДТГ** 5.0 сая төгрөгийн сэргээн засах аппарат худалдан авсан, **ЕБС** тэтгэмж олгосон 3.6 сая, **Цэцэрлэг** шагнал урамшил, сургалт албан томилолт, тэмцээн уралдаанд 4.9 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд байгууллага тус бүрд албан шаардлага хүргүүлээ.

2. **БХС**-ийн Байгаль орчныг нөхөн сэргээх зардлаас 48.1 сая төгрөгийг Бэрх тосгоны ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн, 2.7 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан нийт 50.8 сая, **ОНХС**-д орон нутгийн төсвөөс 19.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчилд зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж тус тус өгсөн.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 16.1 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 290.1 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 9.3 сая, нийт 319.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс:

Цалин хөлсний зардалд 48.3 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 4.8 сая, байр ашиглалтай холбоотой зардалд 1.1 сая, хангамжийн бараа материал худалдан авахад 17.6 сая, эм бэлдмэл нормативт зардалд 104.7 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 3.0 сая, томилолтын зардалд 0.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 14.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 31.2 сая, төрөөс иргэдэд олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 34.2 сая, хөрөнгийн зардалд 60.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагч шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 462.3 сая төгрөгийн 154 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

**Аудитын илрүүлэлт:** Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 599.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд

**ЗДТГ**-ын 185.7 сая, **ЕБС**-ийн 164.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, **ЭМТ**-ийн 249.9 сая төгрөгийн зөрчилд илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх, Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар СХС-ийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхтэй холбоотой 1 албан шаардлага хүргүүлж, өмнөх оны авлагын үлдэгдлийг барагдуулахтай холбоотой 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	19.8	1	19.8			100
Зөвлөмж	1	19.0	1	19.0			100
<b>Нийт</b>	<b>2</b>	<b>38.8</b>	<b>2</b>	<b>38.8</b>			<b>100</b>

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 төрийн сан, 4 тусгай сан, Эмийн эргэлтийн сан нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 төсвийн байгууллага, 1 төрийн санд аудит хийж, ИТХ, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Жижиг дунд бизнесийг дэмжих сан, Байгаль хамгаалах сан, Сум хөгжүүлэх сангууд аудитын түүвэрт хамрагдаж, Эмийн эргэлтийн сан аудитад хамрагдаагүй болно.

Д/д	Байгууллагын нэр	Аудитад хамрагдсан байдал			Дүгнэлтийн хэлбэр			
		Дүгнэлт	Түүвэрт	Хамрагдаагүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Татгалзсан
1	Засаг дарга	+			+			
2	ЗДТГазар	+			+			
3	ЕБСургууль	+			+			
4	Цэцэрлэг	+			+			
5	Эрүүл мэндийн төв	+			+			
6	Соёлын төв		+					
7	ИТХурал		+					
8	Орон нутгийн хөгжлийн сан		+					
9	Байгаль хамгаалах сан		+					
10	ЖДБДСан		+					
11	Сум хөгжүүлэх сан		+					
12	Эмийн эргэлтийн сан			+				
	<b>ДҮН</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>1</b>	<b>5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Батноров сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд "Өндөрхаан итгэл аудит" ХХК аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" санал дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 683.5 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлснээс 263.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 албан шаардлага хүргүүлж, 420.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 74.5 сая төгрөгийн зөрчил илэрч 3 зөвлөмж өгсөн.

#### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй.

#### **Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага**

Төвлөрүүлэн захирагчид акт, албан шаардлага хүргүүлээгүй.

Төвлөрүүлсэн захирагчийн 74.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

### **3.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

#### **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Орлогын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал 0.3 сая, бууны албан татвар 1.3 сая, улсын тэмдэгтийн хураамж 0.5 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 2.1 сая, нийт 4.2 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Эрсдэл:** Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлээгүй байх.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 41.2.1 дэх заалтын дагуу төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлж ажиллах.

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

##### **2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт-1:** ОНХС-д орон нутгийн төсвөөс 19.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

**Эрсдэл:** Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байх

**Өгсөн зөвлөмж:** Хууль тогтоомжид зааснаас өөр орлого төвлөрүүлэхгүй байх.

Хэнтий аймгийн Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

Илрүүлэлт-2: Байгаль орчныг нөхөн сэргээх зардлаас 48.1 сая төгрөгийг Бэрх тосгоны ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн, 2.7 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Эрсдэл: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байх

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b> 2022.04.10	<b>Аудитын нэр:</b>	Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b> ХЭА-2022/14/СТА-ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч		<b>сая төгрөгөөр</b>

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 5.0 сая төгрөгийн сэргээн засах аппарат худалдаж авсан.	5.0	Албан шаардлага өгсөн	Дарга, Нягтлан бодогч	А.Борчулуун, Б.Энхжаргал
2	Шилэн дансанд мэдээлбэл зохих 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 5.0 сая төгрөгийн 1, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 65.7 сая төгрөгийн 2, зарлагын 60.0 сая төгрөгийн 1 гүйлгээ нийт 185.7 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байна.	185.7	Зөвлөмж өгсөн	Дарга, Нягтлан бодогч	А.Борчулуун, Б.Энхжаргал
<b>ЗДТГ-ын дүн</b>		<b>190.7</b>			
1	Батлагдсан төсвөөс үндэслэлгүйгээр 3.6 сая төгрөгийн тэтгэмж олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан.	3.6	Албан шаардлага өгсөн	Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Г.Цэцэгсүрэн, Ч.Саруултуяа
2	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг 6.6 сая төгрөгөөр, цалингийн зардлаас бусад орлогын мөнгөн гүйлгээг 36.7 сая төгрөгөөр мэдээлээгүй, 120.8 сая төгрөгөөр хугацаа хоцроож мэдээлсэн.	164.1	Зөвлөмж өгсөн	Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Г.Цэцэгсүрэн, Ч.Саруултуяа
<b>ЕБС-ын дүн</b>		<b>167.7</b>			
1	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 170,613.3 мянган төгрөгийн 11 худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 51,915.2 мянган төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 27,375.8 мянган төгрөгийн 12 тушаал шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй	249.9	Албан шаардлага өгсөн	Дарга, Нягтлан бодогч	П.Лхагважав, Д.Байгалмаа
<b>ЭМТ-ийн дүн</b>		<b>249.9</b>			

**Хэнтий аймгийн Батноров сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1	Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас шагнал урамшилд 3,000.0 мянган төгрөг, сургалт албан томилолт, тэмцээн уралдаанд 1,906.0 мянган төгрөг, нийт 4,906.0 мянган төгрөгийг зарцуулсан	4.9	Албан шаардлага өгсөн	Эрхлэгч, нягтлан бодогч	Т.Оюунтуяа, Ч.Саруултуяа
	<b>Цэцэрлэгийн дүн</b>	<b>4.9</b>			
1	Өмнөх оны орлогын үлдэгдлээс ОНХС-д хөрөнгө төвлөрүүлсэн.	19.5	Зөвлөмж өгсөн	Засаг дарга, нягтлан бодогч	Д.Жамбаа, Г.Цолмонтуяа
	<b>ОНХС-ийн дүн</b>	<b>19.5</b>			
1	Байгаль орчныг нөхөн сэргээх зардалд зарцуулагдаагүй.	50.8	Зөвлөмж өгсөн	Засаг дарга, нягтлан бодогч	Д.Жамбаа, Г.Цолмонтуяа
	<b>БХС-ийн дүн</b>	<b>50.8</b>			
1	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал 0.3 сая, бууны албан татвар 1.3 сая, улсын тэмдэгийн хураамж 0.5 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 2.1 сая нийт 4.2 сая төгрөгөөр төлбөр хураамжийн орлогыг дутуу биелүүлсэн байна.	4.2	Зөвлөмж өгсөн	Засаг дарга, САД бөгөөд ерөнхий нягтлан бодогч	Д.Жамбаа, Б.Энхжаргал
	<b>ТТЗ -ийн дүн</b>	<b>4.2</b>			
	<b>Нийт дүн</b>	<b>687.7</b>			